



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 26 -ны өдөр

Дугаар А/31

Эрдэнэт

Г"Коронавируст халдвар/Ковид-19/-ын цар тахлын Т
үед ЭМГ-ын албан хаагчдын ажлын
зохион байгуулалт, чиг үүргийг батлах тухай"

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.7, 33.1.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 7.1.8, 37.1.7 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалт, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 18, 20, 21 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайдын "Бүх нийтийн бэлэн байдлын зэргийг сунгах тухай" А/24 дүгээр тушаал Орхон аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 01/502 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Коронавируст халдвар/КОВИД-19/-ын цар тахлын үед урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор багуудыг байгуулан, ажлын чиг үүргийг хавсралтаар баталсугай.

2. Чиг үүргийн дагуу ажлаа хариуцлагатай гүйцэтгэж, үр дүнг тухай бүрт танилцуулж ажиллахыг багийн дарга, гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн газрын даргыг хүндэтгэн үзэх шалтгаантай үед түүний албан үүргийг орлон ажиллах даргаар Яаралтай, гамшгийн үеийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Б.Уртнасанг томилсугай.

4. Албан хаагчдын ажил үүрэг гүйцэтгэсэн нэмэгдэл хөлсийг тухай бүр тооцож олгохыг Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Д.СҮХЭЭ

My doc. EMG-iin dargiin tushaal

Эрүүл мэндийн газрын даргын
2021 оны 03 дүгээр сарын
26-ний өдрийн А/31 дугаар
тушаалын хавсралт



КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД19/-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
АЛБА ХААГЧДЫН ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ

№	Багуудын ахлагчийн нэрс	Хариуцах ажлын чиг үүрэг	Мэргэжилтнүүд	Хийх ажлын чиг үүрэг
1	Удирдлага төлөвлөлтийн багийн дарга Г.Энхжаргал	Хүний нөөцийн төлөвлөлт, мэдээ, тайлан, мэдээллийн ил тод байдлыг хангах, гэрийн ажиглалтад байгаа иргэдийн бүртгэл, хяналт	Г.Энхжаргал	Цаг үеийн нөхцөл байдалтай уялдсан албан бичиг, тушаал, журмыг хянах, боловсруулах
				Эрүүл мэндийн газрын үндсэн үйл ажиллагааг тасалдуулахгүй байхад анхаарч ажиллах
				Цаг үеийн төлөвлөгөөний тодотгол хийхэд хамтран ажиллах, ЭМГ-ын даргаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж, хэрэгжилтийг цаг хугацаанд гаргах, тайлагнах
				Багуудын илтгэх хуудсуудыг хянаж явуулах
			М.Ариунэрдэнэ	ЭМГ-ын ажилтан албан хаагчдыг ээлжийн хуваарьт оруулж ажлын зохицуулалт хийх
				Шуурхай хариу арга хэмжээний багийг томилох
				Тусгаарлах байранд ажиллах хүнийн нөөцийг томилуулах
				Ажилгүй, тэтгэвэрт гарсан эмнэлгийн мэргэжилтний судалгааг гаргаж хүний нөөц бүрдүүлэх
				Давтан сургалтуудыг зохион байгуулах
			С.Мөнхзул	Хяналтын постод ажиллах хүний нөөцийн хуваарь гаргах, үүрэг чиглэлийг өгөх, тайланг нэгтгэх
				Шуурхай штабт ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарь гаргах, зөвлөн туслах, хяналт тавих
				Өдөр бүр нийт салбарын ажилчдын тоог гаргаж, илтгэх хуудсанд оруулах, ЭМС-ын ажилчдын илүү цагийг бүртгэх
	ЭМГ-ын ажилчдын дархлааг дэмжих, амин дэмжүүлэх			

		Г.Итгэл	Цаг үеийн нөхцөл байдлыг мэдээллийг нэгтгэх, цаг хугацаанд нь илтгэх, ЭМГ-ын цахим хуудсуудад тавих, мэдээллийг аймгийн Шуурхай штаб, ЭМГ-ын дарга, багуудын дарга, Х.Цолмонхүү нарт өгөх
		С.Эрдэнэцэцэг Х.Оюунэрдэнэ	Эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээ, тайланг гаргах Цахим сургалтын бэлэн байдлыг хангуулах Гэрийн ажиглалтад байгаа иргэдийг хянах Түргэвчилсэн шинжилгээнд хамрагдсан иргэдийг бүртгэлжүүлэх
		Н.Мөнх-Ундраа	Коронавируст халдвартай холбоотой гарсан ЗГ, УОК-ын оос гарсан тогтоол, журам, аймгийн ЗД-ын захирамж, албан даалгавар, АОК-ын шийдвэр, ЭМГ-ын тушаал, албан бичгийг бүртгэлжүүлж, багийн ахлагч болон холбогдох мэргэжилтнүүдэд шуурхай хүргэх, ЭМС-уудад мэдээллийг хүргэж баримтжуулах, ЭМГ-аас явуулж буй хариутай бичгийг хугацаанд нь хүргүүлэх, эргэн мэдээлэх
	Туслах ажилтнууд	Нярав Б.Алтанзагас	ЭМГ-ын ажилчдыг дархлаажуулах, хамгаалах хэрэгслээр хангах, тараах, бүртгэл хөтлөх, баталгаажуулах Ариун цэврийн өрөө, цэвэрлэгээнд шаардлагатай халдваргүйтэлийн бодисоор хангах Ажилтан, албан хаагчдын өрөө, тасалгаанд хэрэгцээтэй зүйлсэр хангах Шуурхай хариу арга хэмжээний баг болон тусгаарлах байр, постуудад хамгаалах хувцас хэрэгсэл болон бусад шаардлагатай эд материалыг хүлээлгэн өгөх, баримтжуулах, нөөцийн үлдэгдлийн тооцоог гаргах, мэдээлэх
		Үйлчлэгч Х.Наранцэцэг Р.Чулуунханд	Их цэвэрлэгээг 7 хоногийн бүрийн 5 дахь өдөр хийж няравт шалгуулж гарын үсэг зуруулах Өдөр бүрийн цэвэрлэгээний тэмдэглэл хөтөлж багийн даргаар хянуулах Шаардлагатай газар цэвэрлэгээ үйлчилгээний ажлыг хийх
		С.Батжаргал Т.Гонгорням	Байгууллагын барилга байгууламж, эд хөрөнгийг болзошгүй аюулаас хамгаалах, хяналт тавих, орсон гарсан иргэдийг бүртгэлжүүлэх Аж ахуй, тохижолт үйлчилгээний ажилд туслах үүрэг

			Жолооч Ч.Нямдорж	гүйцэтгэх Шаардлагатай газар хүн, эд материалыг саадгүй хүргэж өгөх
2	Эмнэлгийн тусламж үйлчилгээний багийн дарга Б.Уртнасан	Эмнэлгийн тусламж үйлчилгээний зохицуулалт, нөөц хангалт	Б.Уртнасан	Цаг үеийн нөхцөл байдалтай уялдсан албан бичиг, тушаал, журмыг боловсруулах Цаг үеийн төлөвлөгөөний тодотгол хийхэд хамтран ажиллах, ЭМГ-ын даргаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж, хэрэгжилтийг цаг хугацаанд гаргах, тайлагнах Ковидын орны зохицуулалт ЭМЯ-ны Дэд сайдын илтгэх хуудсыг хугацаанд нь хүргэх
			П.Хишгээ	Эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний бусад зохион байгуулалт Эм. тарианы нөөц
			О.Анхбаяр	Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, нөөцийн судалгааг өдөр бүр гаргах, мэдээнд оруулах Шаардлагатай эмнэлгийн хэрэгслийн нөөц хангалтын судалгааг гаргах, танилцуулах
			- -	Эмнэлгийн хэрэгслийн нөөц хангалт тооцоог гаргах
			Д.Отгондэлгэр	Шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэх Хандив тусламж болон ЭМЯ болон орон нутгаас шийдвэрлэсэн хөрөнгө санхүүжилтийг бүртгэлжүүлж цахимд байршуулах
			Н.Чулуун-Эрдэнэ	Түргэвчилсэн тестийн хангалт, татан авалт Илүү цагийн тооцоог гаргах, холбогдох байгууллагуудад албан бичгээр хүргүүлэх, багийн даргыг мэдээллээр хангах Төлбөртэй шинжилгээ хийлгэх аж ахуйн нэгж байгууллагуудын хуваарь гаргаж аймгийн Шуурхай штабт өдөр бүр мэдээг өгөх
3	Нийгмийн эрүүл мэнд, хариу арга хэмжээний багийн дарга А.Баярхүү	Хариу арга хэмжээ	А.Баярхүү	Хариу арга хэмжээг төлөвлөлтийн дагуу зохион байгуулж, тайланг нэгтгэх Цаг үеийн нөхцөл байдалтай уялдсан албан бичиг, тушаал, журмыг боловсруулах Цаг үеийн төлөвлөгөөний тодотгол хийхэд хамтран ажиллах, ЭМГ-ын даргаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж, хэрэгжилтийг цаг хугацаанд гаргах, тайлагнах

			Цагдаагийн газар, Тагнуулын газар, Онцгой байдлын газартай хамтран ажиллах, мэдээлэл солилцох
		Б.Билгүүнээ	Халдварын тандалт судалгаа хийж, ойрын болон дам хавьтлуудыг илрүүлэх, голомтыг цомхотгох арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах
			Голомтын халдваргүйтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах
			Эмч, эмнэлгий мэргэжилтнүүдэд давтан сургалтуудыг зохион байгуулах
		Ө.Наранзаяа	Халдварын тандалт судалгаа хийж, ойрын болон дам хавьтлуудыг илрүүлэх, голомтыг цомхотгоход оролцох
		Н.Мөнгөнцацралт	Шуурхай хариу арга хэмжээний багуудыг хуваарилан ойрын хавьтлуудыг тусгаарлах ажлыг зохион байгуулах
			Шуурхай багт ажилласан ажилчдын илүү цагийг бүртгэж, Хүний нөөцийн мэргэжилтэнд өгөх
		Б.Батцэцэг	Тандалт шинжилгээнд орох хүмүүсийн нэрсийг гаргах, шинжилгээний сорьц хуваарилах, мэдээг Эрүүл мэндийн статистик мэдээллийн мэргэжилтэнд өдөр тутам мэдээлэх
		Т.Байгаль	
		Б.Хишигжаргал	
		Т.Нарантуяа	
		Б.Энхтүвшин	
		С.Эрдэнэцэцэг	Дархлаажуулалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах, хянах
		Б.Хишигжаргал	
		Ө.Наранзаяа	Гэрийн ажиглалтад хяналт тавих, эргэн мэдээлэх ажлыг зохион байгуулах
		Г.Цолмонхүү	
			Сурталчилгааны материал хэвлэх, тараах, Цагийн мэдээллийг бэлтгэх, Facebook, вэб сайтад байршуулах, мэдээллийг аймгийн Шуурхай штаб, ЭМГ-ын дарга, багуудын дарга нарт танилцуулах, зөвлөмж авах
Бүх албан хаагч нарт	<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн газрын албан хаагчид чиг үргийн дагуу ажлаа хариуцлагатай гүйцэтгэж, үр дүнг Багийн дарга нарт, багийн дарга нар Эрүүл мэндийн газрын даргад тухай бүрт танилцуулах Албан хаагчид утсаа байнга нээлттэй байлгах, эргэн холбогдох, өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлж сахилга баттай ажиллах 		